# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 28 өдөр Дугаар А/76 Онги

Намрын өнгө-2023 үзэсгэлэн худалдааг
зохион байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 зүйлийн 66.1дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сайхан-Овоо сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлэх, харилцан туршлага солилцох түншлэл тогтоох, үйлдвэрлэл үйлчилгээг сурталчлах зорилгоор “Намрын өнгө-2023” үзэсгэлэн худалдаа ”-г 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр Соёлын төвд зохион байгуулсугай.

2. “Намрын өнгө-2023” үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэд, аж ахуй нэгж, үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинаци, шалгуур үзүүлэлтийг гаргаж шалгуурын дагуу дүгнэж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. “Намрын өнгө-2023 ” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

4. Үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад шаардагдах 1,230,000 (Нэг сая хоёр зуун гучин мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал), Нягтлан бодогч (Г.Чагдарсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г.ЛУВСАНРАГВА

Сумын Засаг даргын 2023 оны 09
сарын 28-ны өдрийн А/76 дугаар
захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн ахлагч: С.Болоржаргал ( Тамгын газрын дарга)

Гишүүд: Г.Дэлгэрмаа ( Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн )

Р.Тунгалагтуяа ( Санхүү албаны дарга )

Д.Сарнай (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Арсланбаатар (ЕБС-ийн захирал)

Н.Бадамцэцэг (Эрүүл мэндийн төвийн дарга )